

**“НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД
2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
2020 ОНЫ ЭХНИИ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2020.07.08

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төлөвлөгөөний биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6
1	<p>Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын ерөнхий тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.</p>	<p>Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, харилцах утасны дугаар зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх</p>	<p>I, II, III, IV улирал</p>	<p>Сул ажлын байрны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khandaqi.mn цахим хуудас болон байгууллагын ил тод байдлын самбарт нээлттэйгээр, 14 хоногийн давтамжтайгаар шинэчлэн байршуулж байна. Мөн www.ipeqi.mn-д цахим хуудас болон дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан 4 төрлийн ажлын байранд 6 удаагийн давтамжтай захиалга өгч ажиглалаа.</p> <p>Зарын дагуу ирсэн ажил горилгогчдоос сонгон шалгаруулалт хийх байдлаар ажлын байрны сул орон тоог нөхөж ажиллаж буй бөгөөд тодорхой үр чадвар, туршлага шаардсан ажлын байранд албан хаагч сонгон шалгаруулахдаа мөрит зарчмыг удирдлага болгон ажигласнаар 2020 оны эхний хасаг жилд нийт 6 ажлын байрны сул орон тоонд байгууллагын ажигтан, албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна.</p>	<p>100%</p>
		<p>Ажилтан, албан хаагчийн ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилгох</p>		<p>Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мөрит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажигласнаас тайлант хугацаанд тооцооны нягтлан бодогч Х.Бямбанаранг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогчоор, зоогийн газрын зөөгч Д.Оюунтуяаг байр хариуцсан менежерээр, тоног төхөөрөмж хариуцсан техникч Б.Эрдэнэтөгсийг зоогийн газрын менежерээр, зоогийн газрын касс Г.Мөнхцэцэгийг үндсэн хөрөнгө, бараа</p>	<p>100%</p>

				Материалын нярваар, байрны жижүүр Н.Энхбатыг тоног төхрөөмж хариуцсан техникчээр, зоогийн газрын сав угаагч О.Давааг тогочоор тус тус дэвшүүлэн томилсон.	
	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох		Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай болон уг асуудалтай холбогдуулан гарсан ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл гомдол байгууллагад ирээгүй болно.	100%
2	Мэдээллийг хууль ёргодол, хянан шалгах, харууцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.	Коронавируст /КОВИД-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд албан тушаалтны гаргаж буй шийдвэр, байгуулж буй гэрээ хэлцэл нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах	I, II, III, IV улирал	Коронавируст /КОВИД-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд албан тушаалтны гаргаж буй шийдвэр, гуравдагч этгээдтэй байгуулж буй гэрээ хэлцэл нь аливаа байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, шат дамжлагатайгаар хянаж баталгаажуулж байна.	100%
3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалт, давтан сургалт зохион байгуулна.	Эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалтад идэвхтэй хамрагдах	III, IV улирал	Хэрэгжүүлэх хугацаа болгоогүй.	Үнэлэх боломжгүй
4	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчид болон байгууллагын ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг олон эх үүсвэрээр хүлээн авч,	I, II, III, IV улирал	Тайлан гаргах үеийн байдлаар ажилтан, албан хаагчдаас ирсэн нийт 85 өргөдлийг бүрэн шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан. Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад	100%

<p>чанар, үр дүнг сайжруулна.</p>	<p>шуурхай шийдвэрлэх.</p>		<p>зөрчийн үзүүлэлт нэмэгдээгүй байна. Хандалтын хувьд 2019 оны эхний хагас жилд 91, сүүлийн хагас жилд 110 өргөдөл бүртгэгдсэн бол 2020 оны эхний хагас жилд 85 өргөдөл бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 6,59 хувиар буурчээ.</p>	
<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан дүрст сурталчилгааг хийнэ.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас авлигын эсрэг зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас бусад мэдээллийн эх үсвэрээр нийтэд сурталчлах</p>	<p>I, II, III, IV улирал</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан, энэ чиглэлийн мэдээ мэдээллийг байгууллагын www.khangardi.mn цахим хуудас, "Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар" пэйж хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газраас гаргасан албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнтэй танилцах, мэдээлэл өгөх тухай зөвлөмж бүхий шторжыг байгууллагын вэб хуудас болон фасебүүк хуудсанд байршуулан, олон нийтэд сурталчлах ажлыг идэвхтэй зохион байгуулж ажиллалаа.</p>	<p>100%</p>

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

 Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

 Э.ХОРОЛДУЛАМ